

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/228-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Албан шаардлага.....	17
4.2 Зөвлөмж.....	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
НДС	Нийгмийн даатгалын сан



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

БАТЦЭНГЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.ЗОРИГТХҮҮ ТАНАА

2022.03.25 № 169
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *So. Amdb* Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	773,981.0	1,028,085.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	96,313.0	410,982.1
33	АВЛАГА	373,733.9	295,918.0
35	БАРАА МАТЕРИАЛ	303,934.2	304,886.5
36	НӨӨЦИЙН БАРАА	0.0	16,298.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,500,366.7	5,436,788.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,500,366.7	5,436,788.9
39200	Биет хөрөнгө	5,403,355.4	5,340,917.6
39300	Биет бус хөрөнгө	97,011.3	95,871.3
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,274,347.7	6,464,873.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	9,731.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	9,731.6
41300	Өглөг	0.0	9,731.6
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,274,347.7	6,455,142.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,274,347.7	6,455,142.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,975,885.8	1,975,885.8
51200	Хуримтлагдсан үр дүн	3,222,600.5	3,403,395.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,075,861.4	1,075,861.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,274,347.7	6,464,873.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон / мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,648,292.8	3,405,673.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	169,046.8	280,375.7
110	Орлогын албан татвар	111,029.5	110,610.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	111,029.5	110,610.9
113	Хөрөнгийн албан татвар	5,010.0	66,683.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	53,007.3	103,081.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,706,366.4	493,867.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,706,366.4	490,314.5
122	Тусламжийн орлого	0.0	3,553.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,772,879.6	2,631,430.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,203,515.3	3,176,922.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,203,515.3	3,176,922.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,684,949.0	3,094,349.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,725,064.9	1,820,096.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	228,846.4	246,939.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	81,861.5	96,388.6
2104	Хангамж, бараа материалын зардал	82,330.3	87,846.6
2105	Нормативт зардал	122,833.4	415,982.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,985.0	33,234.8
2107	Томилолт, зочны зардал	2,576.8	1,846.5

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	57,988.4	29,714.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	375,462.5	362,301.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	518,566.3	82,572.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,444,777.5	228,750.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	122,083.1	57,901.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,322,694.4	170,848.8

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,951,653.3	4,951,653.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,951,653.3	4,951,653.3
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	1,322,694.4	1,322,694.4
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,274,347.7	6,274,347.7
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,274,347.7	6,274,347.7
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	9,945.8	9,945.8
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,284,293.5	6,284,293.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	170,848.8	170,848.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,455,142.3	6,455,142.3

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,988,475.4	3,000,005.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	169,046.8	280,375.7
110	Орлогын албан татвар	111,029.5	110,610.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	111,029.5	110,610.9
113	Хөрөнгийн албан татвар	5,010.0	66,683.7
118	Бусад татвар, төлбөр, хураамж	53,007.3	103,081.1
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,583.8	9,405.5

1181	Газрын төлбөр	25,048.2	71,917.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,375.3	21,757.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	46,549.0	149,281.9
120	Нийтлэг татварын бус орлого	46,549.0	149,281.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,772,879.6	2,570,348.1
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,854,972.6	2,571,564.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,854,972.6	2,571,564.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,336,406.4	2,488,243.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,724,746.3	1,820,096.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	229,165.0	237,207.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	90,006.3	92,849.4
2104	Хангамж, бараа материалын зардал	77,194.6	70,669.7
2105	Нормативт зардал	79,781.3	144,772.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,420.0	25,071.8
2107	Томилолт, зочны зардал	2,965.7	1,845.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	61,709.3	34,611.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,417.8	61,118.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	518,566.3	83,321.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	133,502.7	428,441.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	150,527.9	113,771.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	150,527.9	113,771.9
2200	Дотоод эх үүсвэрээр	150,527.9	113,771.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-150,527.9	-113,771.9
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-96,000.0	0.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	96,000.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-113,025.2	314,669.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	209,338.2	96,313.0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	96,313.0	410,982.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,745,812.3	2,418,457.5	327,354.8	88.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,438,116.4	2,387,507.5	50,608.9	97.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,401,174.0	2,350,594.3	50,579.7	97.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,780,980.6	1,763,610.6	17,370.0	99.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	233,468.1	229,969.0	3,499.1	98.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,498.1	93,059.2	1,438.9	98.5
2104	Хангамж, бараа материалын зардал	75,341.9	65,978.6	9,363.3	87.6
2105	Нормативт зардал	89,077.4	74,736.7	14,340.7	83.9

Архангай аймгийн Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,210.5	33,710.5	3,500.0	90.6
2107	Томилолт, зочны зардал	1,941.2	1,845.2	96.0	95.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,221.9	12,702.2	519.7	96.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	75,434.3	74,982.3	452.0	99.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,942.4	36,913.2	29.2	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,942.4	36,913.2	29.2	99.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	138,468.9	30,950.0	107,518.9	22.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	169,227.0	0.0	169,227.0	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,745,812.3	2,648,086.8	97,725.5	96.4
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,712,675.2	1,703,472.5	9,202.7	99.5
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	730,891.0	784,581.7	-53,690.7	107.3
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,000.0	15,440.2	24,559.9	38.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	262,246.1	144,592.4	117,653.7	55.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	29,464.2	-29,464.2	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	258,648.1	-258,648.1	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	979.00	979.00	0.0	100.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8	8	0.0	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	145.50	145.50	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	256,870.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232,158.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	195,758.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	56,485.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,238.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	510.2
2104	Хангамж, бараа материалын зардал	4,691.1
2105	Нормативт зардал	70,036.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,387.3
2107	Томилолт, зочны зардал	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,909.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,400.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,400.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,712.5
2200	Дотоод эх үүсвэрээр	24,712.5
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	256,870.8
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	256,870.8
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	81.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	255,519.8
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,269.5

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд дотоод хяналт, ер төлбөрийн данс, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/80 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Батцэнгэл сум нь Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулинд зааснаар хуулиар тусгайлан олгосон чиг үүргийн хүрээнд эдийн засаг, нийгмийн асуудлаар бие даан шийдвэр гаргах, хууль тогтоомжийн биелэлтийг хангах, иргэдэд хуульд заасан үйлчилгээг үзүүлэх, зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байна.

Тус сум нь тайлант онд “Монгол Улсын Засгийн газрын болон Архангай аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн санал санаачилгад үндэслэн “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, үйл ажиллагаагаараа аймагтаа тэргүүлнэ” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Сумын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус сумын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 2,745.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 27.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 20.6 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус сумын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 190.6 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	4
Мөнгөн хөрөнгө	96.3	411.0	314.7	326.8
Авлага	373.7	295.9	(77.8)	(20.8)
Бараа материал	303.9	321.2	17.3	5.7
Үндсэн хөрөнгө	5,500.4	5,436.8	(63.6)	(1.2)
Нийт хөрөнгө	6,274.3	6,464.9	190.6	3.0
Өр төлбөр	-	9.7	9.7	-
Цэвэр хөрөнгө өмч /Засгийн газрын оролцоо, эздийн өмч/	6,274.3	6,455.2	180.9	2.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,274.3	6,464.9	190.6	3.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 326.8 хувиар өссөн байна.

Мөнгөн хөрөнгийн 411.0 сая төгрөгийн үлдэгдлийн 37.1 хувь буюу 152.4 сая төгрөг нь төрийн орон нутгийн орлогын дансны, 26.1 хувь буюу 107.5 сая төгрөг нь ОНХС-ийн, 36.8 хувь буюу 151.1 сая төгрөг нь СХС-ийн дансанд байршиж байна.

- *Авлагын үлдэгдэл өмнөх оноос 20.8 хувиар буурсан байна.*

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос буурсан нь тайлант онд СХС-ийн зээл олгоогүйтэй холбоотой байна. Харин ЭМТ нь ковид цар тахалтай холбоотойгоор ЭМДС-аас 61.1 сая төгрөгийн авлагыг тайлагнажээ.

Нийт авлагын үлдэгдлийн 78.0 хувийг сум хөгжүүлэх сангийн, 20.7 хувийг ЭМТ-ийн, 1.3 хувийг орон нутгийн ерөнхий орлогын тайланд тусгагдсан олон жилийн насжилттай авлага тус тус эзэлж байна.

Дээрх орон нутгийн төсвийн ерөнхий орлогын тайланд тусгагдсан 3.9 сая төгрөгийн авлагын 2.4 сая төгрөг нь 1998 онд сум хөгжүүлэх сангаас олгосон 3 иргэнтэй холбоотой, 1.5 сая төгрөгийн авлага нь 2005 онд үүссэн эзэн холбогдогч нь нас барсан авлагууд байна. 1998 оны авлагыг хууль хяналтын байгууллагаар шийдүүлэх хүсэлтийг тавьсан боловч тухайн зээлийг нотлох баримт материал, гэрээ байхгүй гэсэн шалтгаанаар буцаагдсан байна.

- *Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5.7 хувиар өссөн байна.*

Бараа материалын данс нь 303.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 354.8 сая, хандиваар 270.2 сая, бусад 0.2 сая нийт 625.2 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 607.9 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 321.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт бараа материал үлдэгдлийн 26.9 хувийг ЕБС, 26.3 хувийг ЭМТ, 17.8 хувийг ЗДТГ, 14.8 хувийг хүүхдийн цэцэрлэг, 13.5 хувийг соёлын төв, 0.7 хувийг сумын ИТХ-ын бараа материалын үлдэгдэл тус тус эзэлж байна.

- *Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 1.2 хувиар буурсан байна.*

Үндсэн хөрөнгө данс нь 5,500.4 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 82.8 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 81.4 сая, бусад 118.2 сая төгрөг нийт 282.4 сая төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө акталсны гарз 26.9 сая, тайлант хугацаанд байгуулсан 319.1 сая төгрөгийн элэгдэл нийт 346.0 сая төгрөгөөр буурч, 5,436.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийт үндсэн хөрөнгийн үлдэгдлийн 40.6 хувийг ЗДТГ-ын, 29.3 хувийг ЕБС-ийн, 10.7 хувийг ЭМТ-ийн, 13.3 хувийг соёлын төвийн, 6.0 хувийг хүүхдийн цэцэрлэгийн, 0.1 хувийг сумын ИТХ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдэл тус тус эзэлж байна.

- *Өр төлбөрийн үлдэгдэл нь өмнөх 9.7 сая төгрөгөөр өссөн байна.*

Тайланд онд 9.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь ЕБС-ийн ажилчидтай холбоотой өр төлбөр байна.

- *Цэвэр хөрөнгө өмч нь өмнөх оноос 2.9 хувиар өссөн байна.*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь НББ-ийн бодлогын өөрчлөлтөөр 10.0 сая төгрөг, тайлант үеийн үр дүн 170.8 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Татварын орлого	169.0	280.3	111.3
Татварын бус орлого	1,706.4	493.9	(1,212.5)
Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,699.4	1,712.7	13.3
Орон нутгийн төсвөөс	966.3	585.4	(380.9)
Нэмэлт санхүүжилтийн орлого	78.1	256.9	178.8
НДСангаас санхүүжих	29.1	76.5	47.4
Үйл ажиллагааны орлогын дүн	4,648.3	3,405.7	(1,242.6)
Цалин, шимтгэлийн зардал	1,725.1	1,820.1	95.0
Бусад бараа үйлчилгээний зардал	526.4	882.1	355.8
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	57.9	29.7	(28.2)
Бараа үйлчилгээний бусад зардал	375.5	362.3	(13.2)
Урсгал шилжүүлэг	518.6	82.6	(436.0)
Үйл ажиллагааны зардал	3,203.5	3,176.9	(26.6)
Үйл ажиллагааны бус зардал	122.1	57.9	(64.2)
Үйл ажиллагааны үр дүн	1,322.7	170.8	(1,151.8)

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт өмнөх оноос 13.3 сая төгрөгөөр буюу 0.8 хувиар, Нэмэлт санхүүжилтийн орлого 178.8 сая төгрөгөөр буюу 228.9 хувиар, НДСангийн орлого 47.4 сая төгрөгөөр буюу 162.9 сая төгрөгөөр тус тус өссөн бол орон нутгийн төсвийн санхүүжилт 380.9 сая төгрөгөөр буюу 39.4 хувиар буурсан байна. Татварын бус орлого 71.1 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого буурсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Орон нутгийн төсвийн орлого, зардлын төлөвлөлт

Орон нутгийн төсвийн орлогыг анх 229.5 сая төгрөгөөр төлөвлөж, дээд шатны байгууллагад хүргүүлснийг 84.0 сая төгрөгөөр бууруулан сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 18-ны 06 дугаар тогтоолоор 145.7 сая төгрөгөөр баталсан байна.

Батцэнгэл сумын 2021 оны нийт орлого, санхүүгийн дэмжлэг, төсөвт байгууллагуудад олгох санхүүжилтийг 2,674.4 сая төгрөгөөр анх баталсан бол 2021 оын 12 дугаар сарын 16-ны 8 дугаар тогтоолоор 71.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,745.8 сая төгрөгөөр баталсан байна. Энэ тодотголоор ИТХ-ын зардлыг 7.6 сая, ЗДТГ-ын зардлыг 49.1 сая, ОНХСангийн зардлыг 3.9 сая, ЕБС-ийн зардлыг 42.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн бол хүүхдийн цэцэрлэгийн зардлыг 31.4 сая төгрөгөөр бууруулжээ.

Хүснэгт 3. Сумын төсвийн төлөвлөлт

сая төгрөгөөр

№	Байгууллага, орлогын нэр төрөл	Анх баталсан дүн	Тодотгон баталсан дүн	Зөрүү
1	Сумын төсвийн орлого	145.5	145.5	-
2	ТЕЗ-ийн харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого	175.4	175.4	-
3	Аймгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	265.4	290.4	25.0
4	ОНХС-ийн орлогын шилжүүлэг	114.6	118.5	3.9
5	СӨБ-ийн үйлчилгээ	374.8	343.4	(31.4)
6	ЕБС-ийн үйлчилгээ	915.8	958.0	42.2
7	Соёлын үйлчилгээ	97.2	97.2	-
8	ЭМ-ийн анхан шатны тусламж үйлчилгээ	530.5	530.5	-
9	2020 оны ОН-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	35.2	66.8	31.7
10	2020 оны ОНХС-ийн төсвийн үлдэгдлээс санхүүжих дүн	20.0	20.0	0.0
	Нийт дүн	2,674.4	2,745.8	71.4
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	59.2	66.8	7.6
2	Засаг даргын тамгын газар	387.1	436.2	49.1
3	Орон нутгийн хөгжлийн сан	134.6	138.5	3.9
4	Сум хөгжүүлэх сан	170.2	170.2	-
5	Сургуулийн өмнөх боловсрол	374.8	343.4	(31.4)
6	Ерөнхий боловсролын сургууль	920.8	963.0	42.2
7	Соёлын төв	97.2	97.2	-
8	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	530.5	530.5	-
	Нийт дүн	2,674.4	2,745.8	71.4

3.6.2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2021 оны төсөв тодотгон батлах тухай тогтоолоор сумын төсөвт 17 нэр төрлийн орлогоор 145.7 сая төгрөгийг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 285.2 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 195.8 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын төсвийн орлого

сая төгрөгөөр

Үзүүлэлтийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
1.НИЙТ ОРЛОГО	145.7	285.2	139.5	195.8
2.УРСГАЛ ОРЛОГО	145.7	285.2	139.5	195.8
3.ТАТВАРЫН ОРЛОГО	140.0	280.4	140.3	200.2
4.Орлогын албан татвар	81.3	110.6	29.3	136.1
Хүн амын орлогын албан татвар	81.3	110.6	29.3	136.1
Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар	0.0	0.0	0.0	
Үйл ажиллагааны орлого	2.1	45.5	43.5	2220.6
Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	42.1	52.3	10.2	124.1
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	0.2	11.7	11.6	7812.1
Шууд бус орлого	37.0	1.1	-35.9	3.0
Өмчийн татвар	5.2	66.7	61.5	1289.8
Малын тоо толгойн албан татвар	0.0	61.6	61.6	
Бууны албан татвар	5.2	5.1	-0.1	98.1

Бусад татвар	53.6	103.1	49.5	192.5
Улсын тэмдэгтийн хураамж	2.9	4.1	1.1	138.9
Газрын төлбөр	19.0	71.9	52.9	377.7
-----газрын төлбөр	0.6	0.9	0.2	137.2
-----Газрын дуудлага худалдааны орлого	18.4	71.0	52.6	386.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4.9	0.0	-4.9	0.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6.5	5.3	-1.2	81.8
Байгалийн нөөц ашигласны төлбөр:	20.2	21.8	1.6	107.8
.....Байгалийн ургамал ашигласны төлбөр	0.0	0.0	0.0	
----- ус рашааны нөөц ашигласны төлбөр	8.9	2.6	-6.3	29.2
-----ойн нөөц ашигласны төлбөр	11.2	19.1	7.9	170.3
-----ан амьтаны нөөц ашигласны төлбөр	0.1	0.1	0.0	100.0
5.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5.7	4.9	-0.8	85.7
Төсөвт газрын өөрийн орлого	0.2	0.2	0.0	100.0
Хүү торгуулийн орлого	5.0	3.9	-1.1	78.3
Нэр заагдаагүй бусад орлого	0.5	0.8	0.3	154.6

Тайлант жилд 12 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн бол галт зэвсэгийн албан татвар 0.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4.9 сая, хог хаягдал үйлчилгээний хураамж 1.2 сая, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 6.3 сая, хүү торгуулийн орлогыг 1.1 сая төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь галт зэвсэг эзэмшигч 4 иргэний нэхэмжлэл алдаатай үүссэнээс Эрдэнэмандал сумын орлогын дансанд төвлөрсөн, цар тахалтай холбоотойгоор хөрөнгө оруулалтын ажлууд хийгдээгүй, айл өрхийн хог хаягдлын хураамжийг чөлөөлсөн, “Хасу шивэрт” ахмадын амралт сувилалын газар ажиллаагүй зэрэг нь нөлөөлсөн байна. Харин шууд бус орлого 35.9 сая төгрөгөөр тасарсан нь ХХОАТ-ын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2-т заасны дагуу үйл ажиллагааны орлогод малчин иргэдийн малын гаралтай түүхий эд борлуулсан орлогыг хамааруулж, ноос ноолуурын урамшууллаас авах татвар нь үйл ажиллагааны орлого руу тайлагнах болсноос шалтгаалжээ.

3.6.3 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,745.8 сая төгрөгийг баталснаас 2,438.1 сая төгрөгийг урсгал зардалд, 138.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 169.2 сая төгрөгийг сум хөгжүүлэх сангийн зээлд зарцуулахаар төлөвлөж, нийт зардлын 1,712.7 сая төгрөг буюу 62.4 хувийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 730.9 сая төгрөг буюу 26.7 хувийг орон нутгийн төсвөөс, 262.2 сая төгрөг буюу 9.5 хувийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас, 40.0 сая төгрөг буюу 1.4 хувийг НДС-аас санхүүжүүлэхээр хуваарилжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,418.4 сая төгрөг буюу 88.1 хувьтай байгаа нь урсгал зардлаас 50.6 сая төгрөг, хөрөнгийн зардлаас 107.5 сая төгрөг, сум хөгжүүлэх сангаас 169.2 сая төгрөгийг тус тус зарцуулаагүй, үлдэгдлээр байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант жилд нэмэлт санхүүжилтээр дээд шатны төсвийн захирагчаас 255.5 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.3 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит этгээдээс авсан хандив тусламж 0.1 сая төгрөг нийт 256.9 төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлсний зардалд 56.5 сая төгрөг, ажил олгогчоос төлөх НДШ-д 7.2 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 0.5 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 4.7 сая төгрөг, нормативт зардалд 70.0 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардалд 28.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 26.9 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1.5 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 36.4 сая төгрөг, хөрөнгийн зардалд 24.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд сумын засаг даргын нөөц хөрөнгийг 30.0 сая төгрөгөөр тодотгон баталж, бүрэн зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 50.0 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд өвс тэжээл, өвөлжилтийн бэлтгэлд, 18.5 хувийг 2.1.4 дэх заалтын хүрээнд иргэд байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрлэхэд, 3.2 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 28.3 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 4 үндсэн зорилтын хүрээнд 135 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 70 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 2,745.8 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,418.4 сая төгрөгийг зарцуулж, 88.1 хувийн биелэлттэй байна.

Тус сум нь 17 нэр төрлийн орлогоор 145.7 сая төгрөг төвлөрүүлэхээс 285.2 сая төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 195.7 хувь буюу 139.5 сая төгрөгөөр давж биелсэн боловч 5 нэр төрлийн орлогын төлөвлөгөө 13.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Батцэнгэл сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 5. ТШЗ-ийн аудитын дүнгийн талаар

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЕБСургууль	1	1	1		1	1			
Хүүхдийн цэцэрлэг	1	1		1					
ЗДТГ	1	1	1		1	1			
ИТХурал	1	1	1		1	1			
Соёлын төв	1	1	1		1	1			
ЭМТ	1	1	1		1	1			
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
НИЙТ ДҮН	8	8	5	3	5	5	0	0	0

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан сумын ЗДТГазар, ИТХ, ЕБС, ЭМТ, Соёлын төвийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлтийг өгчээ.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 93.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 17.0 сая төгрөгийн 1 алдааг аудитын явцад залруулж, 1.9 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 7.4 сая төгрөгийн 6 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 66.7 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

Хүснэгт №6. Төсвийн шууд захирагчдын төлбөр зөрчлийн нэгтгэл сая төгрөг

Байгууллагын нэр	Залруулсан алдаа		Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
					Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ			2	3.3	1	1.9	1	1.4		
ИТХурал			2	4.8			2	4.8		
Соёлын төв			2	66.6			1	1.2	1	65.4
ЭМТ	1	17.0	0	0			0	0	0	0
ЕБС			3	1.3			2	-	1	1.3
НИЙТ ДҮН	1	17.0	9	76.0	1	1.9	6	7.4	2	66.7

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдаагүй алдаа зөрчлийг санхүүгийн тайлангийн болон нийцлийн аудиттай холбоотой асуудал гэж ангилан үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой 72.0 сая төгрөгийн 5 зөрчил, нийцлийн аудиттай холбоотой 4.0 сая төгрөгийн 6 зөрчил илэрсэн байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн байна.

- ЗДТГ-ын 2021 оны жилийн эцсийн түлш халаалтын зардлын зарцуулаагүй үлдэгдэл 1.9 сая төгрөгөөр нүүрс нөөцөлж, үлдэгдлийг төвлөрүүлээгүй зөрчилд төлбөрийн акт тогтоосон бол нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас улсын төсвийн байгууллагын ажилтнуудад 1.4 сая төгрөгийн тэтгэмж олгосон зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.
- ИТХ нь тавилгын зардлаас 2.0 сая төгрөгийн зөөврийн компьютер тоног төхөөрөмж худалдан авсан зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн
- Соёлын төв нь 41 нэр төрлийн 65.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссанд холбогдох хууль, журмын дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлсэн.
- ЕБС нь 1.3 сая төгрөгийн баримтыг цахим төлбөрийн ebarimt.mn системд дутуу оруулсан, ном хэвлэл /210404/ зардлын данснаас 0.03 сая төгрөгийн маягтын үнэ, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал /210405/ зардлын данснаас 0.2 сая төгрөгийн маягтын үнэ, 0.03 сая төгрөгийн интернэтийн төлбөрийн үнэ, бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс /210406/ зардлын данснаас 0.07 сая төгрөгийн эм, 0.07 мянган төгрөгийн маягтын зардлыг гаргасан зэрэг зөрчил илэрсэнд зөвлөмж хүргүүлэн ажилласан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Батцэнгэл сумын ТЕЗ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 153 мэдээллээс 117 мэдээллийг хугацаанд нь, 36 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

Батцэнгэл сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Шилэн дансны цахим хуудсанд ЗДТГ-аас 2, ИТХ-аас 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсанд зөвлөмж хүргүүлсэн.
- ЕБС нь Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээлэл огт оруулаагүй, 2 мэдээллийг хугацаа хоцроосон зөрчил илэрсэнд албан шаардлага хүргүүлсэн.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Уг тогтоолын хэрэгжилтийг Тариат сумын ТЕЗ-ийн харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар шалгахад дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Төсвийн хэмнэлтийг 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэн заалттай нийцүүлж үзэхэд Соёлын төв 1.2 сая төгрөг, ИТХ нь 2.8 сая төгрөгийн нийт 4.0 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.
- ЕБС нь МУЗГ-ын "Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад уг тогтоолын 1.3 дахь заалтыг зөрчиж 1 ажилтны цалинг 0.1 сая төгрөгөөр нэмж, 4 ажилтанг тус бүр 1 сарын үндсэн цалин нийт 2.0 сая төгрөгөөр шагнаж, мөн 7 ажилтанг нийт 1.2 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

Иймд дээрх зөрчлүүдэд ТШЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар Засгийн газрын 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагуудыг хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 126.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн бөгөөд хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт сая төгрөг

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж-СХС	1	126.4			1	126.4	0
Нийт	1	126.4			1	126.4	0

Өмнөх зөвлөмжийн дагуу СХС-ийн авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар албан бичгээр хариуг ирүүлсэн боловч тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оноос өссөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт, СХС-ийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн буцаан төвлөрүүлэлт болон Хоршоо хөгжүүлэх сангийн журмын хэрэгжилтийг авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 143.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах, таслан зогсоох 2 албан шаардлага хүргүүлж, дотоод хяналттай холбоотой зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

- Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тулган шалгахад галт зэвсэгийн албан татвар 0.1 сая, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4.9 сая, хог хаягдал үйлчилгээний хураамж 1.2 сая, ус, рашааны нөөц ашигласны төлбөр 6.3 сая, хүү торгуулийн орлого 1.1 сая төгрөгөөр нийт 13.6 сая төгрөгөөр орон нутгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийг мөрдөж, орлогын төлөвлөлтийг бодит тооцоо судалгаанд үндэслэн хийж, нэр төрлөөр жигд ханган биелүүлэх албан шаардлагыг хүргүүллээ.

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тулган шалгахад 15 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн 37.3 сая, 23 зээлдэгчтэй холбоотой чанаргүй 92.2 сая нийт 38 зээлдэгчтэй холбоотой 129.5 сая төгрөгийн төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын /тухайн үед хүчин төгөлдөр байсан/ 4.7-д “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай хэтэрсэн зээлийг барагдуулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Батцэнгэл сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад дотоод хяналт, аудитыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Батцэнгэл сумын ТЕЗ	3	143.1	0	0	0	0	2	143.1	1	0
	Дүн	3	143.1	0	0	0	0	2	143.1	1	0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Батцэнгэл сумын ТЕЗ	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Дүн	1	0	0	0	0	0	0	0	1	0
	Нийт дүн	4	143.1	0	0	0	0	2	143.1	2	0